



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТУГ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар A/257

Улаанбаатар хот

Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ,
тариф мөрдөх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 96 дугаар тогтоол, Ус сувгийн удирдах газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тооцоходоо Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 96 дугаар тогтоолыг даган мөрдсүгэй.

2. Батлагдсан цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Хэрэглэгчдэд үйлчлэх албаны дарга (Ц.Баянзул), Шугамаар ус хангах албаны дарга (Б.Баярбилэг), Зөөврийн ус хангах албаны дарга (С.Одгэрэл), Авто баазын дарга (Л.Энхтөгс), Багахангайн ус суваг ашиглалтын товчооны дарга (Н.Батсайхан)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Эдийн засаг, санхүү бүртгэлийн хэлтэс (Ч.Ариунаа), Үйл ажиллагааны хяналтын хэлтэс (Д.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ус сувгийн удирдах газрын даргын тушаалыг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн A/201 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.





УЛААНБААТАР ХОТЫН "УС СУВГИЙН
УДИРДАХ ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ ТАНАА

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Их тойруу 81/1, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14193
Утас: 7014 7445, Факс: (976) 7014 7444.

Цахим хуудас: info@wsrc.mn, Цахим хуудас: www.wsrc.mn

2023. 10.24 № 01/128
танай -ны № -т

Тогтоол хүргүүлж, үүрэг
даалгавар өгөх тухай

Тус Зохицуулах хорооны 2023 оны 96 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн баталсныг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6455 дугаарт бүртгэгдсэн. Мөн 2023 оны 97 дугаар тогтоолоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн танай байгууллагатай тооцоо хийх цэвэр, бохир усны бөөний тарифыг, 101 дүгээр тогтоолоор ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг, 102 дугаар тогтоолоор "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ЫН танай байгууллагатай тооцоо хийх цэвэр, бохир усны бөөний тарифыг тус тус баталсан тул дээрх тогтоолуудыг хавсралтаар хүргүүлж байна.

Зохицуулах хорооны хурлаар танай байгууллагад дараах үүрэг даалгаврыг өгсөн бөгөөд биелэлтийг жил бүр ирүүлж ажиллана уу. Үүнд:

1. Зохицуулах хорооны 2018 оны 40 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж үндсэн хөрөнгийн элэгдлийн сан байгуулж, зарцуулалтыг тайлagnah;
2. Орлогын нэг төгрөгт ногдох үйл ажиллагааны зардлыг 1.0 төгрөгөөс дээшгүй байлгах;
3. Зохицуулах хорооноос баталсан Аж ахуйн харилцааны дүрэмд нийцүүлэн "Цэвэр бохир усаар хангах үйлчилгээний гэрээ"-г хэрэглэгч тус бүртэй шинэчлэн байгуулах;
4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 2.2.2 дахь заалтыг (...харилцааж буй инженерийн барилга, байгууламж нь дамжин хэрэглэгч үүсгээгүй байх..) хэрэгжүүлж ажиллах;
5. Зохицуулах байгууллагын бүртгэлийн дагуу барилга байгууламжийн цэвэр, бохир усаар хангах гэрээг тухай бүр шинэчлэн байгуулах;
6. Үйлчилгээний чанарыг сайжруулж, үйл ажиллагаагаа хэрэглэгчдэд сурталчлах төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр тайлagnaj ажиллах;
7. Усны алдагдлыг 2 хувиар бууруулж ажиллах;
8. Авлага цуглувалтыг сайжруулах;
9. Тариф нэмэгдсэнтэй холбоотой хэрэглэгчдээс ирсэн гомдол, саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар 2023 онд сар бүрээр тайлagnah.

Хавсралт хуудастай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

142330306



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 10. сарын 16.-ны
өдрийн 6455 дугаарт бүртгэв.

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 09 29
оны сарын өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

**Улаанбаатар хотын цэвэр, бохир
усны үйлчилгээний тариф батлах тухай**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улс хоорондын Мянганы сорилтын компакт гэрээний 8.3-д заасны дагуу батлагдсан Зардал нөхөх төлөвлөгөөг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний хүн амын тарифыг нэгдүгээр, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тарифыг хоёрдугаар, зөөврийн ус хангамж, бохир ус зөөврөөр татан зайлцуулах үйлчилгээний тарифыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид “ТЗЭ” гэх/ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2021 оны 79 дүгээр тогтоолыг дээр дурдсан мөрдөж эхлэх хугацаанаас хүчингүй болсонд тооцсугай.
5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮН

Г.ЦОГТСАЙХАН

Д.АНХБАТ

Ц.БАТЗАЯА

Т.УЛАМБАЯР

Х.ПҮРЭВСҮРЭН

142310041



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 09-р сарын 29-ний өдрийн 96 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт


0023080364
ТУ33847 5611547

Улаанбаатар хотын хүн амд мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф

(НӨАТ-гүй)

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Тоолууртай	төг/л 1.34
		Тоолуургүй	төг/л 1.95
2.	Бохир ус	Тоолууртай	төг/л 1.07
		Тоолуургүй	төг/л 1.43

--- о О о ---



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 09-р сарын 29-ний өдрийн 96 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

**Улаанбаатар хотын үйлдвэр, аж ахуйн нэгж,
байгууллагад мөрдөх цэвэр, бохир усны
үйлчилгээний тариф**

(НӨАТ-гүй)

№		Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	2.69
		Төсөвт байгууллага	төг/л	3.42
		Спирт, архи, пиво, ундаа, усны үйлдвэр, машин угаалга	төг/л	3.56
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/л	2.63
2.	Бохир ус	Доор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	2.25
		Төсөвт байгууллага	төг/л	2.75
		Спирт, архи, пиво, усны үйлдвэр, мах, сүү, талх нарийн боов, эмнэлэг	төг/л	2.92
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, машин угаалга	төг/л	3.85
3.	Урьдчилан цэвэрлэх байгууламжийн бохир ус цэвэрлэх үйлчилгээ		төг/л	3.00

--- о О о ---

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2023 оны 09-р сарын 29-ний өдрийн 96 тоот тогтоолын гуравдугаар хавсралт

9023080364
T33847 5511547

Улаанбаатар хотын зөөврийн ус хангамж,
бохир ус зөөврөөр татан зайлзуулах үйлчилгээний тариф
(НӨАТ-гүй)

№		Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф
1.	Цэвэр ус	Төвлөрсөн шугамын ус түгээх байр	төг/л	1.82
		Зөөврийн ус түгээх байр	төг/л	1.82
		Зуслангийн болон алслагдсан зориулалтын цэгт	төг/л	4.55
		Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад	төг/л	3.68
2.	Бохир ус	Цооногтой айл өрх	төг/л	1.05
		Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	төг/л	1.92

*Тайлбар: Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагад, Цооногтой айл өрх, Цооногтой үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг ангиллуудад тээврийн зардал ороогүй болно.

--- о О о ---